

ШУТИС-ИЙН ПРОФЕССОР БАГШ, АЖИЛТАН АЖИЛЧДЫГ ШАГНАЖ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь боловсрол, шинжлэх ухаан, технологи, соёлын талаархи төрийн бодлого, Засгийн газрын болон ШУТИС-ийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, боловсрол, шинжлэх ухаан, соёлын салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасан ШУТИС-ийн профессор багш, ажилтан, ажилчдыг Монгол Улсын цол хүртээх, одон, медаль, Засгийн газрын шагнал, холбогдох яамдын болон бусад дээд байгууллагын шагналд нэр дэвшүүлэх, уламжлах, ШУТИС-ийн шагналд нэр дэвшүүлэх, шагнуулах тухай хүсэлт, саналыг хүлээн авч судлах, шийдвэрлэх, шагналыг гардуулах, хүндэтгэл үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Монгол Улсын цол хүртээх, одон, медаль, Засгийн газрын шагнал (салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдэг), яамдын болон бусад дээд байгууллагын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх, уламжлах, Монгол Улсын цол, төрийн шагнал хүртсэн, одон, медалиар шагнагдсан хүмүүс хүндэтгэл үзүүлэх

2.1. Нэр дэвшигч нь Монгол Улсын цол, одон, медалийн холбогдох эрэмбийн дагуу өмнөх шагнал хүртсэнээс хойш үр бүтээлтэй ажиллан тодорхой амжилт гаргасан, ажлын амжилт бүтээл нь өмнө шагнал авсан түвшингээсээ ахисан, холбогдох байгууллагын шагналын дүрэм, журамд заасан болзлуудыг тус тус хангасан байвал зохино.

2.2. Засгийн газрын шагналаар шагнагдсан хүнийг Монгол Улсын одон, медалиар шагнуулахаар, Монгол Улсын одон, медалиар шагнагдсан хүнийг Монгол Улсын цол хүртээхээр тус тус нэр дэвшүүлнэ.

2.3. 2.1, 2.2-т заасан болзлуудыг хангасан, Монгол Улсын цол хүртээх, одон, медаль, Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдэг, яамдын шагналаар шагнуулах хүмүүсийг анхан шатанд дараах хурлаар хэлэлцэн нэр дэвшүүлнэ. Үүнд:

2.3.1. Бүрэлдэхүүн болон харъяа сургуульд ажиллагсадыг тухайн сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар;

2.3.2. Их сургуулийн захиргаанд ажиллагсадыг тухайн газар, албаны хамт олны хурлаар.

2.4. Хурлын ирц 75%-иас доошгүй байх шаардлагатай бөгөөд хуралд оролцогчдын 80-аас дээш хувь нь шагналд нэр дэвшүүлэхээр зөвшөөрвөл дэмжсэн хурлын албан тэмдэглэл, тухайн хүний анкет зэргийг, албан бичгээр гаргасан шагнуулах хүсэлтийн хамт Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний газарт ирүүлнэ.

2.5. Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний газар материалыг хянан нэгтгэж, Захиргааны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

2.6. Захиргааны зөвлөгөөнөөс дэмжигдсэн хүний ажил байдлын тодорхойлолтонд Ректор гарын үсэг зурж, их сургуулийн тамга дарна.

2.7. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшигчийн анкет, ажил байдлын тодорхойлолтыг хурлын албан тэмдэглэл, шийдвэрийн хамт тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос 1 жилээс доошгүй хугацааны өмнө сум, дүүргийн Засаг даргад уламжилна.

2.8. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдэг, холбогдох яамдын болон бусад дээд байгууллагын шагналаар шагнуулах нэр дэвшигчийн материалыг тухайн байгууллагын шагналын дүрэм, журамд заасны дагуу бүрдүүлж, тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос 1 сараас доошгүй хугацааны өмнө холбогдох яам, байгууллагад хүргүүлнэ.

2.9. Монгол Улсын цол, төрийн шагнал хүртсэн, одон, медалиар шагнагдсан хүмүүст нийт хамт олныг хамарсан хурал зөвлөгөөн, баярын арга хэмжээ болон Ректорын зөвлөлийн хурал, бүрэлдэхүүн сургуулийн хурал, цуглаан дээр баяр хүргэж, Монгол Улсын цол, төрийн шагнал хүртсэн хүнд их сургуулийн дурсамж, мөнгөн аягатай цагаан идээний дээж, хадгийн хамт, Монгол Улсын одон, медалиар шагнагдсан хүнд мөнгөн аягатай цагаан идээний дээж, хадгийн хамт тус тус гардуулан хүндэтгэл үзүүлэх бөгөөд дурсамжтай холбогдох зардлыг төвлөрсөн арга хэмжээний зардлаас, холбогдох бусад зардлыг шагнагдсан хүний харъяалах нэгж хариуцан гаргана.

Гурав. ШУТИС-ийн шагнал, уг шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх, шийдвэрлэх, шагналыг гардуулах

3.1. ШУТИС нь дараах шагналуудтай.Үүнд:

3.1.1. ШУТИС-ийн Хүндэт доктор

3.1.2. ШУТИС-ийн Хүндэт профессор

3.1.3. *ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл*

3.1.4.ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн шагнал

3.1.5. Ректорын нэрэмжит шагнал

3.1.6. Бүрэлдэхүүн сургуулийн шагнал

3.2. ШУТИС-ийн тэргүүн дээд шагнал болох ШУТИС-ийн Хүндэт доктор цолыг Олон улс ба Монгол улсын төр, нийгэм, шинжлэх ухаан, технологи, боловсрол, тус сургуулийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан улс төрийн нэрт зүтгэлтэн, эрдэмтдэд олгоно.

3.3. ШУТИС-ийн дээд шагнал болох ШУТИС-ийн Хүндэт профессор цолыг тус сургуулийг болон тухайн салбар шинжлэх ухааныг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулсан дотоод, гадаадын эрдэмтэд, бизнесмен, тус сургуульд олон жил үр бүтээлтэй ажиллаж буй багш нарт олгоно.

3.4. ШУТИС-ийн Хүндэт доктор, ШУТИС-ийн Хүндэт профессор цол олгохтой холбогдсон харилцааг “ШУТИС-ийн Хүндэт цол олгох журам”-аар зохицуулна.

3.5. *ШУТИС-ийн дээд шагнал болох “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл” шагналыг тус их сургуулийг болон тухайн салбар шинжлэх ухааныг хөгжүүлэхэд онцгой амжилт гаргаж, үнэтэй хувь нэмэр оруулсан багш ажилтан, ахмад настан болон гадны байгууллагын хүнд олгоно.*

3.6 *ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөлөөр тус их сургуулийн профессор, багш, ажилтнуудаас, Эрдмийн зөвлөлийн шагналаар тус сургуулийн профессор, багш, эрдэм шинжилгээний ажилтнуудаас, Ректорын нэрэмжит шагналаар нийт профессор багш, эрдэм шинжилгээний ажилтан, ажилтан, ажилчдаас, бүрэлдэхүүн сургуулийн шагналаар тухайн сургуулийн нийт ажиллагчдаас тус тус шагнаж урамшуулна.*

3.7. Жил бүрийн багш нарын баяр, шинжлэх ухаан, соёлын ажилтны өдөр, шинэ жилийн баяр болон их сургууль, бүрэлдэхүүн, харъяа сургууль, мэргэжилтэн бэлтгэдэг салбарын тэгш, их ойгоор ШУТИС-ийн шагналд тус тус нэр дэвшүүлэх буюу шагнал олгоно.

3.8. Тус сургууль болон тухайн салбар шинжлэх ухааныг хөгжүүлэхэд үнэлэхүйц хувь нэмэр оруулсан хамтын ажиллагаатай байгууллагын ажилтныг Ректорын нэрэмжит болон бүрэлдэхүүн сургуулийн шагналаар шагнаж болно.

3.9. Хамт олноо манлайлан, шинжлэх ухаан, технологи, боловсрол, тус сургуулийг хөгжүүлэх үйл хэрэгт үр бүтээлтэй ажиллаж, тодорхой амжилт гаргасан ШУТИС-ийн профессор багш, ажилтан, ажилчдыг Ректор тушаал гаргаж, албан тушаалын нэг сарын үндсэн цалингаас хэтрэхгүй мөнгөн шагналаар шагнаж болно.

3.10. *ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл*, Эрдмийн зөвлөлийн болон Ректорын нэрэмжит шагналаар шагнуулахаар 2.3.1, 2.3.2-д дурдсан хурлаас нэр дэвшүүлж, нэр дэвшигчийн товч анкетыг сургуулийн захирлын зөвлөлийн, газар, албаны хамт олны хурлын албан тэмдэглэл, шийдвэрийн хамт тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос 2 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний газарт ирүүлнэ.

3.11. Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний газар материалыг хянан нэгтгэж, Захиргааны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх бөгөөд *ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөлөөр жилд 3 /гурав/ хүртэл хүнийг шалгаруулж, шагнагдсан хүнд өргөмжлөл, мөнгөн урамшуулал /ажиллаж байгаа хүнд албан тушаалын нэг сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал, ахмад настан болон гадны байгууллагын хүнд 800000 найман зуун мянган төгрөгийн урамшуулал/*, Эрдмийн зөвлөлийн шагналаар жилд 15 /арван тав/ хүртэл хүнийг шалгаруулж, хүн тус бүрд Эрдмийн Зөвлөлийн өргөмжлөл, **200000 /хоёр зуун мянган/** төгрөгийн мөнгөн урамшуулал, Ректорын нэрэмжит шагналаар жилд 25 /хорин тав/ хүртэл хүнийг шалгаруулж, хүн тус бүрд Ректорын нэр, гарын үсэг бүхий өргөмжлөл, **100000 /нэг зуун мянган/** төгрөгийн мөнгөн урамшуулал тус тус олгоно.

3.12. *ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл, Эрдмийн зөвлөл, Ректорын нэрэмжит шагналаар шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгохгүй.*

3.13. Бүрэлдэхүүн сургуулийн шагналаар шагнуулах хvmvvсийн асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаараа хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд жилд тухайн йургуулийн нийт ажиллагчдын 10 хүртэл хувьтай тэнцэх тооны хүмүүсийг шалгаруулж, хүн тус бүрд **50000 /тавин мянган/** төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.

3.14. *ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл*, Эрдмийн зөвлөлийн болон Ректорын нэрэмжит шагналтай холбогдох зардлыг ШУТИС-ийн төвлөрсөн арга хэмжээний зардлаас, бүрэлдэхүүн сургуулийн шагналтай холбогдох зардлыг тухайн сургуулиас гаргана.

3.15. *ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл, Эрдмийн зөвлөл, Ректорын нэрэмжит шагналын өргөмжлөлийг Захиргаа, хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж хариуцан бэлтгэж, хэвлүүлнэ.*

1. ШУТИС-ийн Захирлын 2019 оны 9-р сарын 25-ны А/193 тоот тушаалаар оруулсан нэмэлт өөрчлөлт тусгагдсан.

Захиргаа, хүний нөөцийн газар



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СҮРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 4/193

Улаанбаатар хот


“ШУТИС-ийн профессор багш, ажилтан,
ажилчдыг шагнаж урамшуулах журам”-д
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн захирлын 2010 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 116 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн профессор багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

ШУТИС-ийн захирлын 2019 оны 02-р сарын
25-ны өдрийн 1193 тоот тушаалын хавсралт



**ШУТИС-ИЙН ПРОФЕССОР БАГШ, АЖИЛТАН АЖИЛЧДЫГ
ШАГНАЖ УРАМШУУЛАХ ЖУРАМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

Гурав. ШУТИС-ийн шагнал, уг шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх, шийдвэрлэх, шагналыг гардуулах

3.1. ШУТИС нь дараах шагналуудтай.Үүнд:

3.1.3 дахь заалтыг “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл” гэж өөрчлөх

3.1.3 - 3.1.5 дахь заалтыг 3.1.4 - 3.1.6 болгон дугаарлах

3.5. дахь заалтыг “ШУТИС-ийн дээд шагнал болох “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл” шагналыг тус их сургуулийг болон тухайн салбар шинжлэх ухааныг хөгжүүлэхэд онцгой амжилт гаргаж, үнэтэй хувь нэмэр оруулсан багш, ажилтан, ахмад настан болон гадны байгууллагын хүнд олгоно.” гэж өөрчлөх

3.5 - 3.10 дахь заалтыг 3.6 - 3.11 болгон дугаарлах

3.6 дахь заалтын “Эрдмийн зөвлөлийн шагналаар” гэсний өмнө “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөлөөр тус их сургуулийн профессор, багш, ажилтнуудаас,” гэж нэмэх

3.10 дахь заалтын “Эрдмийн зөвлөлийн болон” гэсний өмнө “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл,” гэж нэмэх

3.11 дэх заалтын “Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний газар материалыг хянан нэгтгэж, Захиргааны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх бөгөөд” гэсний дараа “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөлөөр жилд 3 /гурав/ хүртэл хүнийг шалгаруулж, шагнагдсан хүнд өргөмжлөл, мөнгөн урамшуулал /ажиллаж байгаа хүнд албан тушаалын нэг сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал, ахмад настан болон гадны байгууллагын хүнд 800000 найман зуун мянган төгрөгийн урамшуулал/” гэж нэмэх

3.12 дахь заалтыг “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл, Эрдмийн зөвлөл, Ректорын нэрэмжит шагналаар шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгохгүй.” гэж өөрчлөх

3.11-3.13 дахь заалтыг 3.13 - 3.15 болгон дугаарлах

3.14 дэх заалтын “Эрдмийн зөвлөлийн болон” гэсний өмнө “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл,” гэж нэмэх

3.15 дахь заалтыг “ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөл, Эрдмийн зөвлөл, Ректорын нэрэмжит шагналын өргөмжлөлийг Захиргаа, хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж хариуцан бэлтгэж, хэвлүүлнэ.” гэж өөрчлөх

Захиргаа, хүний нөөцийн газар



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/217

Улаанбаатар хот


“ШУТИС-ийн профессор багш, ажилтан,
ажилчдыг шагнаж урамшуулах журам”-д
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.4 дэх заалт, ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн профессор багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам”-ын 3.11 дэх заалтын “...ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөлөөр жилд 3 /гурав/ хүртэл хүнийг шалгаруулж, шагнагдсан хүнд өргөмжлөл, мөнгөн урамшуулал /ажиллаж байгаа хүнд албан тушаалын нэг сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал, ахмад настан болон гадны байгууллагын хүнд 800000 найман зуун мянган төгрөгийн урамшуулал/,...” гэдгийг “...ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөлөөр жилд 5 (тав) хүртэл хүнийг шалгаруулж, шагнагдсан хүнд өргөмжлөл, 1500000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн мөнгөн урамшуулал/,...” гэж өөрчлөн баталсугай.

2. Энэхүү журмын өөрчлөлтийг 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

367041233